



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 оны I улирал

ГАНТАЙЗУНАЙСУЙ

ГАНТАЙ ЗУН АЙСУЙ

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар нэмэгдлээ. Харин иргэдийн зээлийн чанаргүйдэл аажмаар муудаж байна. Энэ оны дундаас төрөөс олгож буй хөнгөлөлт, чөлөөлөлтүүд дуусаж хэвийн горимд шилжинэ. Хэрэв эдийн засгийн салбаруудын идэвхжил нэмэгдэхгүй, иргэдийн бодит орлого өсөхгүй бол чанаргүй зээлийн асуудал томоохон эрсдэлийг дагуулах төлөвтэй байна.

Урд хөршийн цар тахлын эсрэг баримталж буй бодлогын нөлөөгөөр экспортын бодит хэмжээнд өсөлт гараагүйгээс шалтгаалж эдийн засаг 3.8 хувиар агшжээ. Мөн Орос-Украины асуудалтай холбоотой нийлүүлэлт, ложистикийн хүндрэл нь манай улсын гол нэрийн түүхий эдийн бүтээгдэхүүний үнэд нөлөөлж, инфляцын түвшин өндөр хэвээр байхад нөлөөлж байна.

Манай улсын хувьд эдийн засгийн салбаруудыг дэмжиж буй ганц салбар нь банкны салбар байгаа юм. Хэрэв цаашид гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй, эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалж салбаруудын идэвхжил муу хэвээр байвал манай улсын эдийн засаг намар гэхэд ихээхэн хүндрэлд орохоор байна. Гантай зуны намар ургац хүлээдэггүйтэй адил зүйл Монголын эдийн засагт ажиглагдаж байна.




Хилийн хязгаарлалт суларч, гадаад аялал жуулчлал аажмаар нэмэгдэж байгаа нь төгрөгийн хадгаламжийг буурахад нөлөөлөв.

Эдийн засгийн салбарууд аажмаар сэргэх болсон нь төгрөгийн хадгаламжийг өмнөх оны мөн үеэс 3 хувиар, валютын хадгаламжийг 1 хувиар буурахад нөлөөлөв.
Эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэлтэй иргэдийн харилцах нэмэгдэв.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Их наяд ₮

Банкны эх үүсвэр, жилийн бүрийн I улирал.



Онолын
тодорхойлолт

Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

-3%

2022 оны I
улирлын
гүйцэтгэл

2022 ОНЫ БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкууд өөрийн эх үүсвэрээр иргэд, аж ахуй нэгжийг дэмжих зээлийг үргэлжлүүлэн олгосоор байна.



Төв банк бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлснээр 9 хувьд хүрлээ.



Тээвэр ложистикийн хэвийн биш үйл ажиллагаанаас үүдэлтэй эдийн засгийн салбаруудын сэргэлт удаашралтай байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Эдийн засгийн салбаруудын удаашрал нь иргэдийн зээлийн чанарт сөргөөр нөлөөлөөд эхэллээ.



Орос-Украины нөхцөл байдал нь нефть, бордоо, хүнсний үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж нийлүүлэлтийн гаралтай инфляцыг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 он I улирал

Бодлогын хүү нэмэгдсэн хэдий ч банкны зээл өсөлттэй байна.

Банкууд эдийн засгийг дэмжих, салбарын сэргэлтийг хурдасгах зорилгоор иргэд, аж ахуй нэгжид өөрийн эх үүсвэрээр зээл олгосоор байна.


Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+25%

Зээлийн үлдэгдэл дунджаар 25 хувиар өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл ихээр авч байна.


Банкууд иргэдэд хэрэглээний зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин илүү олгожээ. Эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байгаа ч банкууд бизнесийн зээлийг тогтмол олгож байна.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн I улирал

Тэрбум ₮



Бизнесийн зээл олголт, жил бүрийн I улирал.



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр олгосон зээлийн хэмжээ оны эхний улиралд нэмэгдэв.

45%

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд 10
зээл тутмын нэг нь
чанаргүй байна.


10%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Хэрэглээний зээлийн багцын чанар аажмаар муудаж байна.

Төрөөс иргэд, аж ахуйн нэгжид олгож буй хөнгөлөлтүүд зогсож иргэдийн бодит орлого аажмаар буурах нь иргэдийн чанаргүй зээлд сөргөөр нөлөөлж байна.
Цар тахлын үеийн хөл хорио, үйлчилгээний цагийн хязгаарлалт үгүй болсон нь эдийн засгийн салбаруудын сэргэлтийг дэмжиж, бизнесийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жилийн бүрийн I улирал




Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Хилийн хязгаарлалт суларч, гадаад аялал жуулчлал аажмаар Нэмэгдэж байгаа нь төгрөгийн хадгаламжийг буурахад нөлөөлөв.

Эдийн засгийн салбарууд аажмаар сэргэх болсон нь төгрөгийн хадгаламжийг өмнөх оны мөн үеэс 3 хувиар, валютын хадгаламжийг 1 хувиар буурахад нөлөөлөв.
Эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэлтэй иргэдийн харилцах нэмэгдэв.

Банкны эх үүсвэр, жилийн бүрийн I улирал.



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

-3%

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Зээлийн хүү

14.5%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү аажмаар нэмэгдэх төлөвтэй байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь зээлийн хүү аажмаар нэмэгдэх суурь шалтгаан боллоо.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 он I улирал

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив өсөв.


6.5%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хаан банк болон ХХБ-ны актив 0.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.


Банкуудын актив, жил бүрийн I улирлаар харуулав



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 0.2 их наяд төгрөгөөр буурсан байна.

Харин ХХБ, Голомт банк, Хасбанкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр
нэмэгдэв.

2%

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс
гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний
өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг
хэлдэг

Банкуудын өөрийн
хөрөнгийн хүрэлцээний
дундаж

16%


Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж байна.

Эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд банкууд ЖДҮ-дэд зээл олгосон нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бууруулахад нөлөөлөв.

Хаан банк эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн зээлийг хамгийн ихээр гаргасан нь тус банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурахад нөлөөлжээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн I улирал




2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Цар тахал гарсантай холбоотой хөтөлбөрийн зээлээс бусад зээлийн олголт өсөөгүй байна. Улмаар банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн I улирал



2020	2021	2022
Хаан		
2020	2021	2022
ХХБ		
2020	2021	2022
Голомт		
2020	2021	2022
Төрийн банк		
2020	2021	2022
Хас		

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

41%

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


2022 он I улирал: Эдийн засгийн өсөлт -3.8 хувьтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт буурсан нь эдийн засгийн өсөлтийг саарахад нөлөөлжээ. Мөн оны эхэнд Орос-Украины нөхцөл байдлаас шалтгаалж импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, тээвэр ложистикийн асуудал үүссэн нь эдийн засгийн өсөлтийг төсөөлж байснаас доогуур гарахад нөлөөллөө.

Төлөв байдал: Хэрэв цаашид хил, гаалийн нөхцөл байдал хүндрэлтэй, Орос-Украины нөхцөл байдал удаан үргэлжилбэл манай улсын хувьд эдийн засгийн өсөлт ирэх улирлуудад улам агших эрсдэл өндөр байна. Мөн дээрх нөхцөл байдлаас шалтгаалан энэ оныг дуустал инфляц 10 орчим хувьд хадгалахад хүлээлтийг буй болгож байна.


2022 оны эхний улиралд эдийн засаг 3.8 хувиар агшив.

Цар тахлын эсрэг баримталж буй урд хөршийн бодлогоос үүдэлтэй тээвэр, ложистикийн хязгаарлалтын улмаас уул уурхайн салбарын экспортын хэмжээ буурсан нь эдийн засаг агшихад голчлон нөлөөллөө.

Орос-Украины нөхцөл байдлаас улбаатай үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн асуудал нь эдийн засгийн салбаруудын сэргэлтийг удаашрахад нөлөөлж байна.



Эдийн засаг I улиралд
3.8 хувиар агшив.



Урд хөршийн цар тахлын эсрэг
бодлогоос шалтгаалан уул
уурхайн салбар уналттай байна.




Уул уурхайн бус салбарууд алгуур
сэргэж байна.


Урд хөршийн цар тахлын эсрэг баримталж буй бодлогын нөлөөгөөр манай улсын экспорт өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна.

- Нийт экспортын 78.7 хувийг БНХАУ руу экспортолж байна.
- Нүүрсний экспорт өмнө оны мөн үетэй харьцуулахад 16 дахин, төмрийн хүдрийн экспорт 4 дахин буурсан байна.

Экспортын бүтэц, улсаар




Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн, улирлаар




Импортын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 хувиар нэмэгдсэн байна.

- Манай улсын дотоодын цар тахлын эсрэг баримталж буй бодлого аажмаар сулрахын хэрээр импортын бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний 32 хувийг Оросоос, 30.7 хувийг Хятадаас импортолж байна. Харин нийт импортын бүтээгдэхүүний 52.6 хувь нь ОХУ-аар, 47.4 хувь нь БНХАУ-аар дамжин Монгол Улсад орж ирж байна.

Импортын бүтэц, улсаар




Импортын гол нэрийн бүтээгдэхүүн, улирлаар




Орос-Украины асуудал болон цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй инфляцын түвшин өндөр хэвээр байна.

- Орос-Украины нөхцөл байдлаас шалтгаалан нефть болон цахилгаан эрчим хүчний нийлүүлэлтийн доголдол үүсэж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ нэмэгдсэнээр үйлдвэрлэл ба хэрэглээний өртөг, зардлыг нэмэгдүүлэх замаар манай улсын эдийн засаг, инфляцад шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн хоёр жилийн хугацаанд урд хөршийн хил, гааль дээр гацсан нийлүүлэлтийн сувгаас үүдэлтэй манай улсын инфляцын түвшин өндөр байсан бол он гарсаар Орос-Украины асуудалтай холбоотой нефть болон бусад бараа бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр нэмэгдсэнээр инфляцад дахин дарамт үзүүлэх боллоо.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


Төгрөгийн нэрлэсэн ханш чангарч байгаа нь төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөллөө.

- Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад улам үнэтэй болсоор байна.
- Төлбөрийн тэнцэл 953 сая ам.долларын алдагдалтай гарсан. Мөн импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс улбаатай валютын гадагшлах урсгал нэмэгдэх хандлагатай байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл



Эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэх нь иргэдийн валют худалдан авах сэдлийг нэмэгдүүлж байна.

- Цар тахлын үед манай улс валютын нөөцөө эрчимтэй нэмэгдүүлсэн нь гадаад эдийн засгийн томоохон шокийг тэсвэрлэн үлдэх боломжийг бүрдүүлэв.
- Орос-Украины нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдсэнээр голлох валютын ханш савлаж эхлэв.

Валютын ханш огцом хэлбэлзсэн хэдий ч валютын нөөц хангалттай байна.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ам.долларын ханш 3.5 хувиар нэмэгдсэн байна.

